



Нийгмийн халамжаас хамааралтай иргэдтэй холбоотой шинэ дүрэм Олон нийтийн асуудаг түгээмэл асуултууд (ТА)

Дотоодын Аюулгүй Байдлын Департаментаас **Нийгмийн халамжаас хамааралтай иргэдтэй холбоотой** дүрмийн эцэслэн батлагдсан хувилбарыг **2020 оны Хоёрдугаар сарын 24**-ний өдөр нийтэлнэ. Уг шинэчлэгдэн батлагдах дүрэм нь “ногоон карт” –гүй хууль ёсоор амьдарч буй цагаач иргэдэд нөлөөлөх болно.

АНХААРАХ ЗҮЙЛ: Medicaid болон SNAP буюу Хүнсний купон хөтөлбөрөөс бүү гараарай, учир нь эдгээр хөтөлбөрт хамрагддаг цагаачид нь нийгмийн халамжийн шалгалтанд өөрсдийнх нь эсрэгээр нөлөөлөх зөвхөн улсын санхүүжилттэй тэтгэмжийг авдаггүй эсвэл нийгмийн халамжид хамаарахгүй.

Тийм учраас, мэргэшсэн өмгөөлөгч/батлагдсан төлөөлөгчтэй зөвлөлгүүгээр эдгээр хөтөлбөрөөс бүү гараарай. Улс даяарх хөтөлбөрийн жагсаалтыг энэхүү вэбсайтаас та үзэж болно: <https://www.immigrationlawhelp.org>

1. Нийгмийн халамжийн үйлчилгээ гэдэг нь?

Аливаа “ногоон карт” авах хүсэлт гаргасан (LPR буюу хууль ёсны байнгын оршин суугч болох хүсэлт гаргагч) эсвэл АНУ-д нэвтрэх зөвшөөрөл хүсэж буй цагаач иргэн, хувь хүн нь зайлшгүй “улсын нийгмийн халамж” хүсэгч иргэн эсэхийг шалгуулах шаардлагатай. Энэхүү шалгалт нь тухайн хүнийг (1) ирээдүйд ямар нэгэн байдлаар нийгмийн халамжийн хөтөлбөрт орох иргэн мөн эсэхийг (2) тухайн хүн нь одоогоор ямар нэгэн халамжийн үйлчилгээнд бүртгэлтэй эсэхийг болон (3) тус хүсэлт гаргагчийн нас хүйс, орлого, эрүүл мэндийн байдал, англи хэлний түвшин, тэтгэмж олгогч батлан даагчдын мэдээлэл зэргийг хянаж үздэг.

2. Шинэ хууль хэзээ хүчин төгөлдөр болох вэ?

Олон нийтийн дүрмийг 2020 оны хоёрдугаар сарын 24 өдрөөс хүчин төгөлдөр мөрдөх бөгөөд тухайн өдөр болон түүнээс хойш уг хуультай холбоотой бүх хүсэлтүүдийг ирүүлнэ гэж ойлгож болно.

3. Шинээр ямар хөтөлбөрүүдийг нийгмийн халамжаас хамааралтай иргэний хүлээн авдаг тэтгэмж, тусламжид тооцох вэ?

Өнгөрсөн олон арван жилийн турш нийгмийн халамжаас хамааралтай иргэнийг тодорхойлоход тооцогддог тэтгэмж, тусламжид зөвхөн Эмзэг бүлгийн өрхүүдэд зориулсан түр тусламж (Temporary Assistance for Needy Families, TANF), Нийгмийн хамгааллын нэмэлт орлого (Supplemental Security Income, SSI) зэрэг бэлэн мөнгөний тусламж, төрийн санхүүжилттэй удаан хугацааны асрамжийг оруулж тооцож ирсэн. Шинэ дүрмийн дагуу *дараах тэтгэмж, тусламжийг* шинэ хуулийн хөтөлбөр хамруулан тооцож болно:

- **Холбооны санхүүжилттэй Medicaid** (Калифорни муж улсад Medi-Cal гэдэг), гэхдээ дараах зүйлс хамаарахгүй:
 - **Зөвхөн улсын санхүүжилттэй Medicaid*** (зөвхөн улсын санхүүжилттэй хөтөлбөрүүдийг нийгмийн халамжийн шалгалтанд авч үздэггүй)
 - **Яаралтай тусламжийн Medicaid/ Medi-Cal**

Сүүлд шинэчлэгдсэн огноо: 2/7/2020

www.onenationapi.com

- 21-ээс доош насны хүмүүсийн авсан тэтгэмж, тусламж
 - Эмэгтэйчүүд жирэмсэн байхдаа болон жирэмснээс хойших 60 хоногийн хугацаанд авсан тэтгэмж, тусламж
 - Дунд сургуулийн насны хүлээн авагчдад зориулсан сургуульд суурилсан үйлчилгээ
 - Medicaid-ээс санхүүжүүлдэг боловч Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролын тухай хуульд заасан үйлчилгээ
 - Нэмэлт хоол тэжээлийн тусламжийн хөтөлбөр (SNAP буюу Хүнсний купон (Food Stamps); түүнчлэн Калифорний муж улсад CalFresh гэдэг)
 - Орон сууцны тухай хуулийн 8-р хэсэгт заасан Орон сууцны тусламж – эрхийн бичиг, түрээсийн тусламж болон улсын орон сууц
- * Түүнчлэн муж улсын болон орон нутгийн засаг захиргааны удирдан хэрэгжүүлдэг бэлэн мөнгөний бус хөтөлбөрийг нийгмийн халамжаас хамааралтай иргэнийг тодорхойлоход тооцохгүй бөгөөд үүнд зөвхөн муж **улсын санхүүжилттэй Medicaid, SNAP хөтөлбөрүүд** орно.

4. Нийгмийн халамжаас хамааралтай иргэнийг тодорхойлоход харгалзан үзэх өөр хүчин зүйлс бий юу?

Тийм ээ, тус дүрэмд тухайн цагаачлагчийг ирээдүйд нийгмийн халамжаас хамааралтай иргэн болохыг нь тодорхойлоход ашиглаж болох нэлээн хэд хэдэн хүчин зүйлийг тусгасан. Эдгээр хүчин зүйлсэд: нас, орлого, эрүүл мэндийн байдал, боловсролын түвшин;бусад ур чадварууд/англи хэлний мэдлэгийн түвшин/, тусгайлсан нийгмийн халамж авдаг буй тэжээгчийн тэтгэмж, хувийн эрүүл мэндийн даатгал зэргийг хамруулж үзнэ.

5. Би одоо Medicaid, SNAP болон бусад нийгмийн тусламж, үйлчилгээний хөтөлбөрөөс татгалзах хэрэгтэй юу?

Бүх цагаагч иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээ чиглэгдсэн биш болно. Иймд та эхлээд өөрт хамаарах нийгмийн халамжийн үйлчилгээ, түүний холбогдох дүрэм, хуулийн талаар судалж үзэх нь зүйтэй болно. #6 хэсгээс үзнэ үү. Хэрэв та нийгмийн халамжийн шалгалтаар орох гэж байгаа бол энэ талаар мэргэжлийн өмгөөлөгч/албан ёсны төлөөлөгчтэй зөвлөх хэрэгтэй болов уу. Та мөн дараах веб хуудаснаас улс орон даяар хэрэгжиж буй нийгмийн халамжийн үйлчилгээний талаар мэдээллийг авч болно: <https://www.immigrationlawhelp.org>

Улсын нийгмийн халамжийн үйлчилгээний шалгалтад төрөөс олгож буй бүх үйлчилгээ, хөтөлбөрүүд хамарч буй **БИШ** юм.Иймд та дор дурдагдсан онцлох чухал нийгмийн халамжийн үйлчилгээг үргэлжлүүлэн авах, гэр бүлийн гишүүдээ тэтгэх боломжтой эсэхийг шалгана уу:

- **Эрүүл мэндийн халамж:** Medicaid (Хүүхэд, жирэмсэн эхчүүдэд зориулсан болон зөвхөн улсын санхүүжилттэй Medicaid); Medicare эрүүл мэндийн халамж үйлчилгээ; Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох халамж
- **Эрдэс тэжээлийн халамж:** Хүүхэд, эмэгтэйчүүд, насан хүрээгүй хүмүүс; Сургуулийн өглөө, өдрийн цайн хөтөлбөр
- **Хүүхдийн халамжийн үйлчилгээ:** Хүүхдийн халамж, төрийн болон ерөнхий боловсролын сургалт
- **Ажил эрхлэлтийн халамж үйлчилгээ:** Ажилгүйдлийн тэтгэмж; ажилтны нөхөн олговор болон төрөөс олгож буй тэтгэвэр, тэтгэмж хамаарна.
- **Бэлэн бус мөнгөн тэтгэмж** гэдэг улсын болон орон нутгийн төрийн албан хаагчдад хамаарна.

6. Энэ хууль нь хүн бүрд нөлөөлөх үү?

Сүүлд шинэчлэгдсэн огноо: 2/7/2020

www.onenationapi.com

Үгүй, нийгмийн зарим бүлэг нийгмийн халамжаас хамааралтай иргэдэд хамаарахгүй. Үүнд дараах бүлгүүд орно:

- АНУ-ын харьяалалтай иргэд
- Ихэнх албан ёсны байнгын оршин суугч (#9 хэсгээс үзнэ үү)
- Дүрвэгсэд болон орогнол хүсэгчид
- Насанд хүрээгүй цагаачлагчийн эрх зүйн тусгай байдал
- U цагаачлалын бус эрх зүйн байдал
- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн тухай хуулийн (VAWA) дагуу өөрөө хүсэлт гаргагч
- T цагаачлалын бус эрх зүйн байдал
- DACA
- TPS (түр хамгаалалттай эрх зүйн байдал)
- Бусад (Амеразиг гаралтай иргэд; Афганистан, Иракийн цэргийн орчуулагчид; Куба, Хаитийн зарим тусгай нөхцөлтэй хүсэлт гаргагчид; NACARA хөтөлбөрт хамаарах Никарагуа болон Төв Америкийн бусад зарим улсын иргэд; Бүртгэлийн хэсэгт заасны дагуу хүсэлт гаргагчид; ЗХУ болон Зүүн өмнөд Азийн орнуудад зориулсан Лотенбергийн хөтөлбөрөөр ирсэн тэнсэн харгалзах ялтай иргэд;)

7. Би албан ёсны байнгын оршин суугч (LPR) (өөрөөр хэлбэл ногоон карттай) юм; би нийгмийн тусламж, үйлчилгээний хөтөлбөрүүдэд хамрагддаг ч гэсэн нийгмийн халамжаас хамааралтай иргэдтэй холбоотой шинэ хууль гарснаас хойш иргэний харьяалал хүсэх өргөдөл гаргаж болох уу?

Тиймээ болно. Хэрэв та иргэний харьяалал хүсэж буй LPR бол нийгмийн тусламж, үйлчилгээний хөтөлбөр ашиглахтай холбоотой ямар ч асуудал гарахгүй бөгөөд үүнийг харгалзан үзэхгүй.

8. Ирээдүйд намайг нийгмийн тусламж, үйлчилгээний хөтөлбөр ашигласны төлөө албадан гаргах боломж байгаа юу?

Шинэ хуульд бэлэн мөнгөний тусламж болон удаан хугацааны асрамжийн үйлчилгээнд Medicaid, SNAP, Орон сууцны тусламжийн хөтөлбөрүүдийг нэмж, хуульд хамрагдах хөтөлбөрүүдийг өргөжүүлснээс өөрөөр албадан гаргах хэм хэмжээнд ямар ч өөрчлөлт оруулаагүй. Гэсэн хэдий ч, АНУ-ын Хууль зүйн департамент ирээдүйд албадан гаргах хэм хэмжээнд өөрчлөлт оруулахаар төлөвлөж байна. Гэхдээ одоогоор ямар нэгэн өөрчлөлт хийгдээгүй байгаа болно.

9. Би хууль ёсны байнгын оршин суугч (LPR) юм; би АНУ-аас гадагшаа зорчоод буцаж ирэхдээ нийгмийн халамжаас хамааралтай иргэдтэй холбоотой хуулийн талаар санаа зовох хэрэгтэй юу?

Урьдын адил LPR статустай иргэдэд АНУ-аас гадагшаа зорчихдоо 180 хоногоос илүү хугацаагаар ЗОРЧИХГҮЙ байхыг зөвлөдөг. Хэрэв та АНУ-ын хилийн гадна 180 хоногоос илүү хугацаагаар байсан бол таныг шинэ зорчигч гэж үзэн, шинэ хуулийг хэрэглэсний дараа нийгмийн халамжаас хамааралтай иргэн гэж тооцож болно. LPR статустай иргэдийн одоо баримталдаг зарчмын дагуу та гадаадад зорчих хугацаагаа 180 хоногоос хэтрүүлэхгүй байх шаардлагатай байна.

10. Хэрэв би нийгмийн тусламж, үйлчилгээний хөтөлбөр ашигладаг бол гэр бүлийнхээ гишүүдэд тэтгэмж үзүүлж болох уу?

Харилцан адилгүй байна. Гэр бүлийн гишүүддээ тэтгэмж олгох тухай хууль хараахан өөрчлөгдөөгүй байгаа. Та одоо ч гэсэн АНУ-д гэр бүлийн гишүүдээ авчрах хүсэлт гаргаж болно. Гэхдээ та нийгмийн тусламж, үйлчилгээний хөтөлбөр ашиглаж байгаа бол та тэднийг санхүүгийн хувьд дэмжинэ гэдгээ нотлон харуулах "тэтгэмж олгох баталгаа" гаргах боломжгүй байж болно.

Та тэтгэмж олгох баталгаа гаргахдаа та өөр хэн нэгнийг хайх шаардлага үүсэж болзошгүй. Энэ талаар та нийгмийн халамжийн талаар мэргэшсэн өмгөөлөгчтэй зөвлөсөн нь дээр болов уу.

11. Би албан ёсны баримт бичиггүй. Би Medicaid, SNAP болон бусад хөтөлбөрт хүүхдүүдээ хамруулах хүсэлт гаргавал тэд намайг цагаачлалын хууль сахиулах байгууллагад мэдээлэх боломжтой юу?

Үгүй. Таны нийгмийн тусламж, үйлчилгээний хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргахдаа өгсөн мэдээллийг цагаачлалын хууль сахиулах зорилгоор ашиглах боломжгүй. Шинэ хуулиар үүнийг өөрчлөхгүй. Түүнчлэн, хэрвээ та хүүхдийнхээ өмнөөс хүсэлт гаргаж байгаа бол зөвхөн хүүхдийнхээ цагаачлалын эрх зүйн байдлын тухай мэдээллийг өгөх шаардлагатай буюу та албан ёсны бичиг баримтгүй байсан ч хүүхдийнхээ өмнөөс хүсэлт гаргаж байгаа бол, та өөрийн цагаачлалын эрх зүйн байдлын талаар ямар нэгэн мэдээлэл, өөрийн цагаачлалын мэдээллийг өгөх шаардлагагүй болно. Энэ тохиолдолд та "Би өөртөө эрүүл мэндийн даатгал (эсвэл хүнсний купон) хүсэж өргөдөл гаргаагүй" гэж хэлж болно.

Та дээрх нийгмийн халамжаас хамааралтай хуулийн зөвлөгөө хүсэж буй цагаач иргэн бол Улсын Нийгмийн Халамжийн Үйлчилгээний үнэлгээ боловсруулах шалгуурыг сайтар судалж **Илүү дэлгэрэнгүй мэдээллийг** авах хэрэгтэй. Энэ талаарх дэлгэрэнгүй мэдээлэл KeepYourBenefitsCA.org веб хуудсанд англи хэл дээр, Харин Испани хэлээр авах бол TusBeneficiosPublicos.org хаягаар зочлох боломжтой. Уг тэтгэмж үйлчилгээний талаарх мэдээллийг бичгээр авах бол **(650)376-8006** дугаарт "Benefits" гэж бичсэнээр англиар, "Libre" гэж бичсэнээр Испани хэлээр, харин "福利" (Хятад хэлээр) эсвэл "lợi ích" гэж бичиж илгээснээр Вьетнам хэлээр авах боломжтой болно.